



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 6/14

Зуунмод

Төрийн албан хаагчдын ангилал зэрэглэл,
цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2, 3, 6, 6 дугаар хавсралтын 2.1, 2.2., 2.3, 2.4, 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10, 2024 оны 128 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 3, 4, 10, 11 дүгээр хавсралт, 2024 оны 240 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 6, 7 хавсралт, 2024 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" тогтоолын 1 дүгээр хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 2023 оны 03 дугаар тогтоолын 16 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар "Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тоо батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралт, 2024 оны А/232 дугаар "Хавсралтад өөрчлөлт оруулах тухай" захирамжийн 1 дүгээр хавсралт, Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймгийн Худалдан авах ажиллагааны газарт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалин хөлс, нэмэгдлийг нэгдүгээр, төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалин хөлс, нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Батлагдсан орон тоо цалингийн санд багтаан албан хаагчдын цалинг хавсралтын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцон олгохыг Нягтлан бодогч (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад зохих үүрэг гүйцэтгэдэг үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох эсэх асуудлыг холбогдох нийтлэг журмын хүрээнд тухай бүр санал, дүгнэлт гаргаж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Б.Болдбаяр), Нягтлан бодогч (Б.Бямбасүрэн) нарт даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны "Албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай" Б/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Б.Болдбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б. ГАНХУЯГ



Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 09 -ны өдрийн 6/4 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ АЖИЛЛАХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД
(Албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу олгох цалин хөлсний жагсаалтын хамт)

Албан тушаал	Овог нэр	Төрийн албанд ажил асан жил	Төрийн албаны ангилал, зэрэг дэв	Зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл				ТОГ хавсран гүйцэтгэгч (хавсран ажилласны)	
						ОН-Т ажилласны нэмэгдэл (382 тортон 2.1)	ОН-Т ажилласны нэмэгдэл (382 тортон 2.3)	Зэрэг дэв, цол	Урьдчилсан үнэмлэхүй гэрээний үндсэн дээр (Нүүцт, Н. Мэргэлийн зэрэг М. ЭБАТ-Э)		
Төрийн захиргааны албан хаагч											
Ахлах мэргэжилтэн	А.Зоригоо	18.08	Дэс түшмэлийн Тэргүүн зэрэг	T3-8	1,320,000	18%	20%	50%	24%	-	-
Хуулийн мэргэжилтэн (ТОГ)	Б.Болдбаяр	16.05	Дэс түшмэлийн Тэргүүн зэрэг	T3-9	1,210,000	16%	20%	50%	24%	-	-
Худалдан авах ажиллагаа харуицсан мэргэжилтэн	Г.Тамирмаа	9.02	Дэс түшмэлийн Тэргүүн зэрэг	T3-9	1,210,000	9%	20%	50%	24%	-	-
Худалдан авах ажиллагаа харуицсан мэргэжилтэн	Ш.Мөнхзул	7.09	Дэс түшмэлийн Гутгаар зэрэг	T3-9	1,210,000	7%	20%	50%	20%	-	-
Худалдан авах ажиллагаа харуицсан мэргэжилтэн (ТОГ)	Г.Ариун-Уянга	8.03	-	T3-9	1,210,000	8%	20%	50%	-	-	-

_____ ооо

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын
 Даргын С.У.Оны 09 дугаар сарын 09 -ны
 өдрийн Б/У дүгээр турвалын 4 дугаар хавсралт



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИН ХӨЛСӨЙГ ШИНЭЧЛЭСЭН ЖАГСААЛТ

Албан тушаал	Овог нэр	Төрийн албанд ажилласан жил	Зэрэглэл	Үндсэн цалин	Нэмэгдэл				Хавсран ажилласны нэмэгдэл
					Төрийн алба хаасан хугацааны	ОН-1 ажилласны нэмэгдэл (382 тогтоол 2.11)	ОН-1 ажилласны нэмэгдэл (382 тогтоол 2.3)	Ур чадвар	
Төрийн үйлчилгээний албан хаагч									
Нягтлан бодогч	Б.Бямбасүрэн	8.03	ТҮМ-6	1,400,000	8%	20%	50%	-	-
Архив, бичиг хэргийн ажилтан, Нярав	Т.Ууганбаяр	2.11	ТҮМ-3	1,210,000	2%	20%	50%	-	-

_____ ооо



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар Б/15

Зуунмод

**Болдын Болдбаярыг ажилд
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3, 57 дугаар зүйл 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.3 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор баталсан "Журамд өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2, Засгийн газрын 2024 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 3, 10 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр Тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь хэсэг, 2023 оны 312 дугаар тогтоолоор баталсан "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" тогтоолын 1.3 дахь заалт, 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 12.3 дахь заалт, Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 16 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тоог батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 32 дугаар тогтоол, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны Б/14 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Хуулийн мэргэжилтний албан тушаалд Болдын Болдбаярыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ний өдрөөс жинхлэн томилсугай.
2. Б.Болдбаярын албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэл 1,210,000 (Нэг сая хоёр зуун арван мянга) төгрөгөөр тогтоож, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 16 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 50 хувиар бодож тус тус олгосугай.
3. Б.Болдбаярын албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлүүдийг 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны "Б.Болдбаярыг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай" Б/08 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн (А.Зоригоо)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б. ГАНХУЯГ





**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 16 өдөр

Дугаар Б/16

Зуунмод

Намсрайн Эрдэнэболдыг ажилд
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3, 57 дугаар зүйл 57.2.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.3 дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны 382 дугаар Тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолоор баталсан "Журамд өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 2, Засгийн газрын 2024 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 3, 10 дугаар хавсралт, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр Тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10 дахь хэсэг, 2023 оны 312 дугаар тогтоолоор баталсан "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолын 1, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 526 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт батлах тухай" тогтоолын 1.3 дахь заалт, 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын 12.3 дахь заалт, Төв аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 17 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 16 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/758 дугаар захирамжаар баталсан "Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм, бүтэц орон тогтоог батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралт, Төрийн албаны зөвлөлийн төв аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны 32 дугаар тогтоол, Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны Б/14 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтний албан тушаалд Намсрайн Эрдэнэболдыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. Н.Эрдэнэболдын албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэл 1,210,000 (Нэг сая хоёр зуун арван мянга) төгрөгөөр тогтоож, зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 18 хувиар, орон нутагт ажилласан нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 50 хувиар бодож тус тус олгосугай.

3. Н.Эрдэнэболдын албан тушаалын үндсэн цалин, нэмэгдлүүдийг 2024 оны 05 сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн (А.Зоригоо)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭН
Б.АНХУЯГ





**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 6/17

Зуунмод

Г Болдын Болдбаярыг эрх бүхий Г
албан тушаалтнаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 57 дугаар зүйлийн 57.12, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам"-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Хуулийн мэргэжилтэн Болдын Болдбаярт албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, үнэлгээний хороонд томилогдсон албан тушаалтны ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс томилон албан үүргийг хариуцан гүйцэтгүүлсүгэй.

2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн бөгөөд эрх бүхий албан тушаалтан (Б.Болдбаяр)-д үүрэг болгосугай.

3. Б.Болдбаярт эрх бүхий албан тушаалтны албан үүргийг гүйцэтгэсний нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тооцож 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Нягтлан бодогч (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б. ГАНХУЯГ



**ТӨВ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 6/18

Зуунмод

Ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2, 109 дүгээр зүйлийн 109.6, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын 3, 10 дугаар хавсралт, Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр 20-ны өдрийн А/758 дугаар захирамж, Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны А/03 тушаалын 1 дүгээр хавсралт, Худалдан авах ажиллагааны газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын Хуулийн мэргэжилтэн (Б.Болдбаяр)-д тус газрын авто машины ашиглалт, хамгаалалтыг хариуцуулан жолоочийн ажил үүргийг 2024 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Б.Болдбаярын ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг ТҮ-3 (Жолооч) ангилал, зэрэглэлд заасан үндсэн цалингийн 40 хувиар тооцож 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцож олгохыг Нягтлан бодогч (Б.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, Б.Болдбаяртай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон нэмэгдэл хөлсний хэмжээг тусгаж баталгаажуулах, жолоочийн ажлын байрны тодорхойлолтоор заагдсан үүргийн хэрэгжилтийг хангуулахыг Ахлах мэргэжилтэн (А.Зоригоо)-д, хөдөлмөрийн аюулгүй байдлыг чанд сахин, авто машины бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Б.Болдбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНХУЯГ

